



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 89

Номгон

“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам” шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, архидан согтуурахтай тэмцэх зорилгоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журам батлагдсантай холбогдуулан 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө олгосон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа журмын нэг дэх хэсгийг баримталж, шинээр олгохдоо журмыг хэрэгжүүлж худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон цэгийн тоо нормативт нийцүүлэн арга хэмжээ авч, цагийн хуваарийг өвөл, зуны байдлаар тогтоон мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.


3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулсан тухайн жилийн борлуулалтын орлогын нэгээс доошгүй хувийг архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахад зориулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд уриалсугай.

4. Журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Д.Уранчимэг/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Д.Ихбаяр/, Мэргэжлийн хяналтын газар /Н.Бямбадорж/, Цагдаагийн газар /Ц.Анхбаяр / нарт тус тус үүрэг болгосугай.

5. Журмын хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам шинэчлэн батлах тухай” 2018 оны 80 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
19-ний өдрийн 89 дүгээр тогтоолын хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР
ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ,
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ”**

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаа, /цаашид тусгай зөвшөөрөл гэнэ/ тусгай зөвшөөрлийг олгох, сунгахад бүрдүүлэх материал, аж ахуйн нэгж, иргэнд тавигдах шаардлага, хүлээх үүрэг, хориглох зүйл, тавих хяналт, хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

НЭГ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

1.1 Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгж /хуулийн этгээд/, тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрх бүхий иргэнд сонгон шалгаруулалт явуулж аймгийн Засаг даргын захирамжаар олгоно.

1.2. Сумын Засаг дарга сонгон шалгаруулалт явуулах эрх бүхий 5 хүн /Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Байгаль орчны улсын байцаагч, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажилтан, Хэсгийн төлөөлөгч, Тухайн багийн Засаг дарга, эрх бүхий улсын байцаагч/-ийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилно. Ажлын хэсэг нь энэхүү журамд заасны дагуу сонгон шалгаруулалтыг явуулж санал гаргана.

1.3. Ажлын байрны шаардлага, техникийн нөхцөлийн үзүүлэлтийг бүрэн хангасан аж ахуйн нэгж, тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрх бүхий иргэнийг шалгаруулна.

1.4. Сонгон шалгаруулалтыг явуулахдаа техникийн нөхцөлд зайлшгүй шаардлагатай дараах үзүүлэлтийг харгалзана.

1.5. Объектын гадна орчны цэцэрлэгжүүлэлт, талбайн тохижилт, тусгай гэрэлтүүлэг, тусгайлан зассан машины зогсоолтой байх.

1.6. Барааны зураасан код унших тооцооны машиныг үйл ажиллагаандаа ашигладаг байх.

1.7. Объектын гадна болон дотор талд гэрэлтүүлэггүй орчинд дүрс таних хүчин чадалтай 30-аас доошгүй хоног дүрс бичлэг хадгалах төхөөрөмж бүхий шаардлага хангасан хяналтын камер суурилуулсан байх.

1.8. Монгол Улсын хууль тогтоомж болон тусгайлан зохицуулсан журмыг зөрчөөгүй байх.

1.9. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаа явуулах ажлын байр, ажиллах хүчний нөөц нь Монгол Улсын “Худалдааны газрын үйлчилгээ” MNS 5021:2007 стандартыг хангасан талаар Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гарсан байх

1.10. Ажлын байр нь галын аюулгүй байдлыг хангасан байх.

1.11. Хэрэв сонгон шалгаруулалтын талаар маргаан үүссэн бол дээд шатны байгууллага, албан тушаалтад гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХОД

ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Тусгай зөвшөөрлийг олгоход дараах материалуудыг бүрдүүлнэ.

2.1.1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл

2.1.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ

2.1.3 Тусгай зөвшөөрөл хүсэгч иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар

2.1.4 Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ

2.1.5 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулсан ажлын хэсгийн санал

2.1.6. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

2.1.7. Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний асуудал хариуцсан улсын байцаагчийн дүгнэлт

2.2 Тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгоно.

2.3. Тусгай зөвшөөрлийг олгохдоо шинэ бүтээн байгуулалт, дэвшилтэт үйлчилгээ эрхлэх, ажлын байр шинээр бий болгосон үйлчилгээг /аялал жуулчлал, зочид буудал, зоогийн газар/ дэмжиж олгоно.

2.4. Кафены ангиллаар үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвхөн сул агууламжтай согтууруулах ундаа /дарс, шар айраг/-аар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоно.

2.5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тусгаж өгнө.

2.6. Энэ журмын 1.1-1.10-д заасан шаардлагыг хангаагүй талаар ажлын хэсгийн санал гарсан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ

3.1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг зөрчөөгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгах шийдвэрийг аймгийн Засаг дарга гаргана.

3.2. Тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө сумын Засаг даргад дараах материалыг ирүүлнэ.

3.2.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөл

3.2.2. Цагдаагийн газрын тодорхойлолт /тусгай зөвшөөрөл авсан хугацаанд ямар нэгэн хэрэг зөрчил гаргаагүй тухай/

3.2.3. Сумын Засаг даргын санал, ажлын хэсгийн дүгнэлт

3.2.4 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

3.2.5.Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний асуудал хариуцсан улсын байцаагчийн дүгнэлт

3.3. Сумын Засаг дарга материалыг хүлээж авснаас хойш ажлын 5 хоногийн дотор саналаа холбогдох материалын хамт аймгийн Засаг даргад ирүүлнэ.

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

4.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлага, энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд сумын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн албан бичгээр гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлнэ.

4.2. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлага энэхүү журмыг зөрчсөн тохиолдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан баримтуулж зөрчил гаргагчид танилцуулсан байвал зохино.

4.3. Түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилган холбогдох байгууллагаар шалгуулсан тухай дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийн эрхийг анх авсан зөвшөөрлийн үлдсэн хугацаагаар сэргээнэ.

ТАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

5.1 Дараах тохиолдолд хүчингүй болгоно.

5.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрөө хүсэлт гаргасан.

5.1.2. Хуулийн этгээд татан буугдсан болон худалдаа, үйлчилгээний газраа бусдад худалдсан, бэлэглэсэн.

5.1.3. Стандартын бус бүтээгдэхүүн худалдсан, түүгээр үйлчилж иргэдийг хохироосон нь тогтоогдсон.

5.1.4. Онцгой албан татварын тэмдэггүй, хуурамч тэмдэгтэй, үндсэн баримтгүй болон хуурамч баримттай худалдаа үйлчилгээ эрхлэн Татварын болон холбогдох бусад хуулийг зөрчсөн.

5.1.5. Зөвшөөрөл олгосноос хойш байршлаа өөрчилсөн буюу тусгай зөвшөөрлийн эрхийг бусдад шилжүүлсэн.

5.1.6. Тусгай зөвшөөрөл гарсанаас хойш 21 хоногт аваагүй, олгосноос хойш үйл ажиллагаа эхлээгүй 3 сар болсон.

5.1.7. Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.

5.1.8. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, нийцүүлэн гаргасан журмыг зөрчиж хоёр буюу түүнээс дээш удаа захиргааны арга хэмжээ авагдсан.

5.1.9. Эрх бүхий албан тушаалтанд шалгуулахаас татгалзсан буюу шалгалтаас санаатайгаар зайлсхийсэн.

5.2. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг Хууль эрх зүйн хэлтэс холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид албан бичгээр ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

5.3 Зөрчлийн талоныг 3 удаа цоолуулсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ЗУРГАА. ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХЭД ХОРИГЛОХ ТУХАЙ

6.1. Аймгийн хэмжээнд 7 хоног бүрийн даваа гарагийг “Архинаас татгалзах” өдөр болгож энэ өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

6.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт болон гар дээрээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

6.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг ашиглан зөвшөөрөгдсөн байршлаас буюу тухайн байр /танхим/-аас бусад газарт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх.

6.4. Тусгай зөвшөөрлийн эрхийг бусдад худалдах, түрээслүүлэх, гэрчилгээг хувилж олшруулах, өөр ажлын байранд шилжүүлэх, бусдад ашиглуулах,

6.5. Худалдааны газарт согтууруулах ундааг савлах, аягалж хундагалж худалдах.

6.6. Зоогийн газар, баар, кафед халуун хоол, хүйтэн зуушгүйгээр согтууруулах ундаагаар үйлчлэх.

6.7. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тогтоосон цагийн хуваарийг зөрчиж, худалдаа, үйлчилгээ явуулах.

6.8. ААН, иргэн нь аливаа албан тушаалтны албан бичиг, ам шийдвэрээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулах.

6.9. Бөөний худалдааны төв нь чанар аюулгүй байдал, стандарт тохирлын баталгаагүй, онцгой албан татварын шошиггүй согтууруулах ундаа худалдах, дагалдах, баримт бичиггүйгээр согтууруулах ундааг бөөнөөр худалдаалахыг тус тус хориглоно.

ДОЛОО. СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Улсын бүртгэлийн гэрчилгээ, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээ, бүтээгдэхүүн тус бүрийн шинжилгээний бичиг, улсын байцаагчийн дүгнэлт, бэлтгэн нийлүүлсэн газрын зарлагын баримт /тамга, гарын үсэгтэй байх/ зэрэг бичиг баримтын бүрдлийг байнга ханган шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдэд чирэгдэлгүй шалгуулна.

7.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэрэглэгчдэд харагдахуйц газар байрлуулан, аймгийн Засаг даргын баталсан цагийн хуваарийг хатуу чанд мөрдөж ажиллана.

7.3. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллага хамт олны дунд зохион байгуулж байгаа ажил, сайн туршлагаа сурталчилах архинаас гарсан хүмүүсийг шагнаж урамшуулахад санаачилгатай ажиллана.

7.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь албан өрөө, ажлын байр, агуулах болон үйлчилгээний танхимд согтууруулах ундаа хэрэглэхгүй улмаар хамт олноороо согтууруулах ундаа хэрэглэдэггүй, архигүй орчин бүрдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна.

7.5. Хууль, хяналтын байгууллага, аймаг сумын төрийн байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, иргэд үйлчлүүлэгчдээс гарсан санал гомдлыг барагдуулахад хариуцлагатай хандаж ажиллана.

7.6. Зөвхөн стандарт, чанарын баталгаатай хүнсний бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, зөв хадгалан боловсруулж, Монгол Улсын “Төрөл бүрийн архи техникийн өрөнхий шаардлага” MNS179:2009 стандартад нийцсэн согтууруулах ундаагаар худалдаалж, үйлчилнэ.

7.7. Зоогийн газар, баар, кафе нь үйлчилгээнд шаардагдах цэвэр үзэмжтэй хийгдсэн хоолны цэстэй байна.

7.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэн нь архины талаарх хориглосон болон далд сурталчилгааг явуулахыг хатуу хориглох бөгөөд Зар сурталчилгааны тухай болон Өрсөлдөөний хуулийг чанд баримтлана.

7.9. Суурилуулсан камерийг байнгын ажиллагаатай байлгах бөгөөд бичлэгийг устгахдаа Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

7.10. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх иргэн, аж ахуйн нэгжийн ажилтан нь мэргэжлийн үнэмлэхтэй, тогтмол хугацаанд эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдана.

НАЙМ. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

8.1. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН, иргэний үйл ажиллагаа болон журмын хэрэгжилтэд бүх шатны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, ХЭАХН, аймаг сумын Засаг даргын шийдвэрээр баталгаажсан ажлын хэсгийн гишүүд хяналт тавина.

ЕС. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

9.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Энэхүү журмыг зөрчиж согтууруулах ундаа худалдсан түүгээр үйлчилсэн аж ахуйн нэгж, иргэний тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар хүчингүй болгоно.

9.3. Тусгай зөвшөөрөлгүйгээр архи, согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн бол согтууруулах ундааг хураан улсын орлого болгож, хуульд заасан арга хэмжээг авна.

9.4. Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн оноогоор тооцож хариуцлага хүлээлгэнэ.